# СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Жилээр | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1:** Идэвхтэй хөдөлгөөн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөл бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах | | | | | | | |
| | **Стратеги төлөвлөгөөний зорилго 1** Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан төлөв насан туршийн дадал олгох зорилт бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх | 43.6 сая | Иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшин дээшилсэн, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөл сайжирч биеийн тамирын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байх | Биеийн тамир, өдөрлөгийн арга хэмжээ-8, сорил хүн амын 10,1%, спорт заал- 52, мэдээллийн сан- 60 %. | Биеийн тамирын өдөрлөгийн арга хэмжээ 6, сорил хүн амын 9,3, спорт заал 52, мэдээллийн сан 80 % | 2023 оныг байгууллагаас “Хүүхдийн бие бялдрыг дэмжих жил” болгон Хүүхдийн спортын наадамтай уялдуулан аймгийн хэмжээнд спортын 13 төрлөөр хүүхдийн дунд сонгон шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан нийт 3500 гаруй хүүхдийг хамруулан 230 гаруй тамирчдыг сонгон шалгаруулж Баянхонгор аймагт зохион байгуулагдсан ХСНаадамд 18 төрлөөр оролцуулан 10 төрөлд 13 алт, 10 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж Улсад 21 аймгаас тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн.<br>Иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшин дээшлүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх боломжийг бүрдүүлэхээр гаргасан аргачлалын дагуу 2023 онд 4 сумын саналыг хүлээн авч эхний ээлжинд /Орхон, Сайхан, Дулаанхан/ зэрэг сумд орон нутгийнхаа хэмжээнд өдөрлөг арга хэмжээгээ явуулан нийт 4240 иргэнийг хамруулсан байна. Нэг арга хэмжээг явуулахад байгууллагаас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 800000 төгрөгийн дэмжлэг үзүүлж одоогоор 5 арга хэмжээнд 4000000 төгрөгийн санхүүжилтийг 4 суманд олгосон. Үйл ажиллагаа нээгдэн биеийн тамирын болон спортын арга хэмжээг явуулж эхлэн спортын ордон, 8 цогцолбор, бусад сумдад аймгийн хэмжээний нийт 68 арга хэмжээнд 14273, Улсын аварга шалгаруулах 35 тэмцээн, аймагт зохион байгуулсан 11 удаагийн бүс болон УАШТэмцээн, ААШалгаруулах 16 тэмцээнд 8009 тамирчин, дэлхийн аварга, гадаадын 4 тэмцээнд 54 тамирчныг хамруулаад байна.<br>/2023 оны байдлаар "Цаг гаргая" аянд **19616** нийт **136** арга хэмжээнд **41952** иргэнийг оролцуулан **45,7** хувьд хүрсэн / | |
| 1,1 | **Арга хэмжээ-1:**<br>Аж ахуйн нэгж дэх биеийн тамирын арга хэмжээний цар хүрээг сайжруулах ажлын хүрээнд биеийн тамир спортын холбоо цогцолборын тоог нэмэгдүүлнэ. | Улсын төсөв 10,000,0 | Биеийн тамирын хамтлагийн нийт тоо | Спортын цогцолбор 7<br>Спортын холбоо 21 | Алтанбулаг сумын спорт цогцолбор ашиглалтанд оруулах 4 орон тоог бий болгох | 2023 оны байдлаар спортын 8 цогцолбор, 23 спортын холбоо клуб, 9 фитнес клуб ажиллаж байна. Сэлэнгэ аймгийн таеквондогийн холбооны үйл ажиллагааг шинэчлэн удирдах зөвлөлийг байгуулан шинэ зорилтот тогтолцоогоор ажил үүргээ эхлүүлсэн.<br>Орхон, Жавхлант суманд Биеийн тамир спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын цогцолбор барих газрын асуудал, зураг төслийг боловсруулан 2024 оны улсын төсөвт тус бүр 1,871,1 төгрөгийг суулгаж шийдвэрлүүлсэн.<br>Сум орон нутгийн 1,518,0 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүдэр, суманд спортын цогцолборын барилга угсралтын ажлыг "Морин сувд констракшин" ХХК хийж гүйцэтгэн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | |
| 1,2 | **Арга хэмжээ-2:** Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил аван, дүн мэдээг нэгтгэн Биеийн тамир, спортын улсын хорооны биеийн тамирын хэлтэст программаар тайлагнана. | Улсын төсөв 200.0 | Сорилд хамрагдсан хүн амын эзлэх хувь ба тэдгээрээс А, В, С-гийн эзлэх хувь | 2020 онд хүн амын 19.1 хувь хамрагдаж А, В, С-гийн эзлэх хувь 59 хувь, | Сорилд хүн амын 10,1% хамруулж А,В,С-гийн эзлэх хувийг 59,5 хүрсэн байна. | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт бие бялдрын түвшин тогтоох сорилыг тусгаж өгснөөр тухайн анги бүлэг, хүүхдийн түвшинг тодорхойлох аргачлал болсон бөгөөд эхний хагас жилд сорилд **6-64** насны **6327** гаруй хүүхдийг хамруулж хамрагдсан хүүхдийн 0,5 хувь хэт таргалалт, хөдөлгөөний хомсдолтой бөгөөд Цагааннуур сумын спорт цогцолборын аргазүйч нар хэт таргалалтаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна. Биеийн тамир спортын улсын хорооноос бүх сумдын арга зүйч нарт шинэ сорил болох иргэдийн бие бялдрын ерөнхий хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох сургалтад хамруулан Танида / Антропометр/ хэмжих багажийг бүрэн эзэмшүүлж орон нутгийн хэмжээнд 1 багажтай болж эхний ээлжинд 8 цогцолбортой сумдад ажиллан 160 иргэний судалгааг авч тэдэнд үр дүнгийн талаар тайлбарлан зөвлөгөө өгч ажилласан. /нийт 32147хүн / | 100 |
| 1.3 | **Арга хэмжээ 3** Байгууллагаас 2023 оныг " Хүүхдийн бие бялдарын хөгжлийг дэмжих жил" ажлын хүрээнд 17 суманд бүх насны хүүхдийг оролцуулсан биеийн тамирын арга | Улсын төсөв 20,6 | Оролцсон хүүхдийн тоо | 0 | 17 суманд биеийн тамир спортын 15 төрлийн арга хэмжээг явуулж 4000 гаруй хүүхдийг оролцуулсан байна | Өсвөрийн үеийн дунд "Монгол наадгай" өв соёлыг өвлүүлэн үлдээх чиглэлээр 5 бүсийн хэмжээнд 17 сумыг хамруулан зохион байгуулж 255 хүүхдийг оролцуулсан. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Алтан намар" урлаг спортын цуврал арга хэмжээг сургууль тус бүр дээр явуулах чиглэлийн дагуу 17 сум, 6 тосгоны 34 сургуулиудад үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг зохион байгуулна | | | | | ажиллагааг явуулан 15300 гаруй хүүхэд хамрагдсан.<br>УИХурлын гишүүн Ч.Ундрамын санаачилгаар Сэлэнгэ Бодонгууд сагсан бөмбөгийн холбоотой хамтран шилдэг тамирчдыг тодруулахаар 17 сум 6 тосгоны Ерөнхий Боловсролын 34 сургуулиудын 10-12 ангиудын дунд "Сэлэнгэ лиг" тэмцээнийг Мандал бүс / Баянгол, Сайхан ,Орхон, Орхонтуул, Сант, Хушаат/ Сүхбаатар бүс /Алтанбулаг, Ерөө, Цагааннуур, Шаамар, Зүүнбүрэн, Түшиг, Жавхлант, Хүдэр/ хуваагдан нийт 480 гаруй тамирчдыг оролцуулан тоглож түрүүлсэн багт бусад багаас шигшин бүх оддын тоглолтыг 2 бүсийн дунд явуулан, Сэлэнгэ лиг" тоглолтонд бодонгууд баг тэргүүлсэн. | |
| 1,4 | **Арга хэмжээ-4**<br>Биеийн тамир, спортын төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлж, хамтын ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх | - | Спортын холбоодоор гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний тоо | 15 | 20 | 2023 онд улс, аймгийн төсөв санхүүгээр ард иргэдийн эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдал, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр биеийн тамирын арга хэмжээ, сарын аян, гүйлт, зэрэг нийт 136 арга хэмжээнд иргэд тамирчдыг хамруулан төрийн болон төрийн бус 82 байгууллага /ЗДТГазар, Эрүүл мэндийн газар , Онцгой байдлын Газар, Аймгийн ахмадын зөвлөл, Цагдаагийн газар, Сэлэнгийн долгио чуулга, Дугуйн холбоо, Бүжгийн холбоо, дартсын холбоо, шатрын холбоо, алхалтын холбоо, Сумдын ЗДТГ, спортын цогцолборууд гэх мэт/ хамтран ажилласан. | 100 |
| 1,5 | **Арга хэмжээ-5:**<br>Биеийн тамирын арга зүйчдийн мэдлэг | 1,5 сая | Сургалтад хамруулсан арга зүйчдийн тоо | 9 арга зүйч | 10 арга зүйч | Ажилтан, албан хаагчдад боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад бүрэн хамруулах чиглэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжлийг дээшлүүлэх сургалтад хамруулна. | | | | | баримтлан ажиллаж нийт 14 удаагийн сургалтад 304 албан хаагчийг бүрэн хамруулсан байна.<br>• Биеийн тамир улсын хорооноос - 5<br>• Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс-2<br>• Мэргэжил дээшлүүлэх сургалтад 2<br>• МСБХолбооны шүүгчийн сургалт<br>• Байгууллагын доторх 5 сургалт | |
| 1,6 | **Арга хэмжээ-6:** Спортлог-Сэлэнгэчүүд "аймгийн хөтөлбөрийн хүрээнд идэвхтэй хөдөлгөөн, өдөрлөг, арга хэмжээг хүн амын зорилтот түвшин, хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн салбар зэрэгтэй уялдуулан зохион байгуулна. | | Идэвхтэй хөдөлгөөн, өдөрлөг, уламжлалт арга хэмжээг тухайн жилийн зорилттой уялдан зохион байгуулсан өдөрлөгийн тоо хамрагдсан иргэдийн тоо | Идэвхтэй хөдөлгөөний 5 өдөрлөг, уламжлалт 3 арга хэмжээнд 5400 иргэн хамрагдсан | Идэвхтэй хөдөлгөөний уламжлалт 5, өдөрлөг арга хэмжээ зохион байгуулж 6400 иргэн хамрагдсан байна. / | Байгууллагаас 2023 оныг "Хүүхдийн бие бялдрыг дэмжих жил" болгон аймгийн 17 сумын хэмжээнд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 13 удаа, өсвөрийн улсын аварга 6 тэмцээнийг орон нутагт хүлээн авч, улсын аварга шалгаруулах 36 тэмцээнд нийт 4897 тамирчинг хамруулан Хүүхдийн спортын наадамд 230 тамирчин оролцуулж 10 төрөлд 13 алт, 10 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж Улсад 21 аймгаас тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. 2023 онд 4 сумын зорилтот бүлгүүдийн дунд нийтийг хамарсан арга хэмжээг явуулан нэг арга хэмжээнд 800000 төгрөгөөр тооцон 4000000 төгрөгийг санхүүжилтийг олгон 4450 гаруй иргэдийг хамруулсан.<br>Аймгийн хэмжээнд 173 секц сургалтад 4500 гаруй хүүхэд, залуучууд хичээллэж, спортын 8 цогцолбор, спортын ордонд биеийн тамирын арга хэмжээ аян, өдөрлөг, гүйлт гимнастикийн арга хэмжээг цахим болон бодит хэлбэрээр 68 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удаа явуулан тус үйлчилгээнд 14273 хүнийг хамруулан хөдөлгөөний дутагдал, таргалалтаас урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>Улсын аварга шалгаруулах 36 тэмцээн, аймагт зохион байгуулсан 11 удаагийн бүс болон УАШТэмцээнд 4897 тамирчин, дэлхийн аварга, гадаадын 6 тэмцээнд 54 тамирчинг хамруулаад байна."Цаг гаргая" 3 сарын аяны хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллага бүрт хуваарь гарган иргэн бүрийг хамруулах зорилгоор үйл ажиллагааг өглөө бүр явуулж хэвшүүлэн аймгийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд маш идэвхтэй хамрагдаж 19616 хүнийг татан оролцуулсан байна.<br>"Цаг гаргая" аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэн энэ ажлын хүрээнд спорт заал болон усан спорт сургалтын төв, Баянгол, Алтанбулаг, Дулаанхан, Цагааннуур, Ерөө, Мандал, Сайхан, Баруунбүрэн сумдын спорт зааланд өглөө бүр иргэдэд 7,00- 9,00 цаг хүртэл өдөр бүр 2 цаг үнэ төлбөргүйгээр үйлчилгээг явуулсан.<br>/ 2023 оны байдлаар нийт хүн амын **41952** иргэнийг оролцуулан **45,7** хувьд хүрсэн / | |
| 1.7 | **Арга хэмжээ-7:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан идэвхтэй хөдөлгөөний арга хэмжээ зохион байгуулна | Орон нутгийн төсөв 1 000 0 | Нийтийн эрүүл мэндийг дэмжих жил"-ийн төлөвлөгөөнд тусган аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлтэй хамтран зохион | 1 арга хэмжээ | 2-арга хэмжээ зохион байгуулж 56 иргэн хамрагдсан байна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортод татан оролцуулах чиглэлээр жүдо, шатар, даам, хөнгөн атлетик гэх мэт олон төрлүүдэд 30 гаруй тамирчин хичээллэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах жүдогийн тэмцээнд 11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулсан арга хэмжээний тоо, хамрагсдын тоо | | | тамирчинг оролцуулан 2 алт 2 мөнгөн медаль хүртэж багаараа 2 дугаар байранд шалгарсан амжилтыг үзүүллээ.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хүүхдийн спортын наадамд аймгаа төлөөлөн парахөнгөн атлетик, жүдо ширээний теннисний төрлөөр 11 тамирчинг оролцуулан 2 алт /ширээний теннис, хөнгөн/ 2 хүрэл /хөнгөн/ медаль хүртсэн сайхан амжилтыг үзүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суугаа волейболын тэмцээнийг Мандал сумaнд зохион байгуулан арга хэмжээнд 4 сум 1 тосгоны 7 багийн холимог 49 тамирчин оролцож Мандал сумын 1 баг тэргүүлсэн. Нийт 6 арга хэмжээнд 242 ХБИргэдийг татан оролцуулсан. | |
| 1.8 | **Арга хэмжээ-8:** Ахмадын тэмцээн уралдаан, идэвхтэй хөдөлгөөний арга хэмжээг аймгийн Ахмадын хороотой хамтран зохион байгуулна. | Орон нутгийн төсөв 1 000 0 | “Нийтийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн төлөвлөгөөнд тусган аймгийн Ахмадын хороотой хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагсдын тоо | 1 арга хэмжээ | 2 арга хэмжээ зохион байгуулж 140 иргэн хамрагдсан байна. | Ахмадын софт волейболын тэмцээнийг Сайхан сумaнд зохион байгуулан түүнд 6 сумын 9 багийн 40 гаруй ахмадууд оролцсон. Ахмад тамирчдын алдрыг мөнхжүүлэх тэдний гавьяа зүтгэлийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, ахмадаас суралцах, ахмад багш нараа сурталчилан ОУХМ, залуучуудын дэлхийн аваргын анхны мөнгөн медальт С.Батсүх агсаны нэрэмжит чөлөөт бөхийн U-17 насны УАШТэмцээн, ахмад багш, БТСТАжилтан, АБТАжилтан С.Алтанчимэг багшийн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах өсвөрийн хөнгөн атлетикийн тэмцээнийг зохион байгуулсан. | 100 |
| 1.9 | **Арга хэмжээ-9:** Усан спорт сургалтын төвийн усан | Улсын төсөв 5, 000 0 | Ашиглалтын нягтралыг сайжруулж Усан | Бассейнд 800 Фитнесс 35 | Аймгийн чанартай тэмцээн хийх насны бүлгээр | Усан спортын чиглэлээр Улаанбаатар хотын Усан бассейн төвтэй хамтран багшийн мэргэжил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бассейны зогсонго байгаа үйл ажиллагааг идэвхжүүлэн, сургалтыг тогтмолжуулан, хүүхэд залуусыг өргөнөөр хамруулна. | | бассейнд үйлчлүүлсэн иргэдийн тоо: спининг төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо: | | Усан бассейнд-1100<br>фитнест-50 | дээшлүүлэх сарын сургалтад 1 багшийг хамруулан секц дугуйланд 1231 тамирчинг сургалтанд хамруулж усан спортын Улсын аварга шалгаруулах 2022 оны тэмцээнд 10 тамирчинг оролцуулан 3 тамирчин улсын 2-р зэргийн норм биелүүлэн, 1 тамирчин алтан медаль 2023 онд 16 тамирчинг оролцуулан 3 тамирчин 1 дүгээр зэргийн норм биелүүлж 3 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. ХСНаадамд 13 тамирчинг оролцуулан багийн өвөр сэлэлтээр 3 дугаар байр эзлэн хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цомын төлөөх тэмцээнд 27 тамирчинг оролцуулан алт 2, мөнгө 5, хүрэл 11 хүртсэн амжилтуудыг үзүүлээд байна.<br>“Цаг гаргая” 2 сарын аянд өглөө бүр үнэ төлбөргүй үйлчилгээг хүргэн 2755 хүнд үйлчилсэн байна.<br>Усан спорт сонирхогчдын дунд “Би сэлж сурсан” усан спортын аварга шалгаруулах тэмцээнийг 3 удаа зохион байгуулан явуулж түүнд 110 гаруй тамирчдыг хамруулсан. Усан спортоор нийт 4176 иргэнд үйлчилгээг үзүүлсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1,10 | **Арга хэмжээ 10**<br>Өртөөт марафон, гимнастрада арга хэмжээг орон нутагт зохион байгуулж явуулах | | | | | “Эерэг хандлага-эрүүл Монгол иргэн ” үндэсний хөдөлгөөн дор гимнастрада аймгийн аварга шалгаруулах ажлын байрны дасгалын тэмцээнийг явуулан 13 сум байгууллагын 130 тамирчид амжилттай оролцож Сэлэнгийн долгио чуулгын баг тамирчид тэргүүлсэн.<br>Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын нэрэмжит “Сэлэнгэ Марафон 2023” нээлтэй тэмцээн 2 дахь удаагаа Хэт холын марафон гүйлтийн холбоотой хамтран Сүхбаатар суманд зохион байгуулсан. Тэмцээнийг Сэлэнгэ аймгийн иргэдийн дунд хүүхэд 1000, 2000, 3000, залуучууд 18-35, 36-49, ахмадууд 50+ ангиллаар, нээлттэй тэмцээн залуучууд 18-35, 36-49, ахмадууд 50+ ангиллаар зохион байгуулагдаж тэмцээнд 15 аймаг 26 спортын холбоо клуб улаанбаатар хотын 3 дүүрэг, Сэлэнгэ аймгийн 12 сумын нийт 460 гаруй гүйгчид тэсвэр тэвчээр хурд хүчээ сорин уралдсан. Тэмцээний гол онцлог нь уг тэмцээнд Монгол улсын шилдэг тамирчид болон Олон улсын хэмжээний мастер 6, спортын мастер 15 оролцсон тэмцээний нэр хүндийг өргөжүүллээ. Сэлэнгэ аймгийн гүйгчдээс өсвөрийн тэмцээнд Таван хан гүйгчдийн холбоо, Алтанбулаг сум, Баянгол сум эхний гурван байранд шалгарсан бол насанд хүрэгчдээс Алтанбулаг сум, Сүхбаатар сум, Хэрх тосгон эхний гурван байр эзэлж, нээлтэй марафон гүйлтэнд тэргүүн байранд Монголын хэт холын марафон гүйлтийн холбоо удаах байранд Алдар спорт хороо, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хилчин спортын хороо шалгарсан. Тэмцээнийг өргөжүүлэх зорилгоор бүх оролцогчдын дунд энгэрийн дугаараар сугалааг явуулж азтануудыг тодруулсан нь тэмцээний зохион байгуулалтыг сайжруулсан сэтгэл санааг нь өргөжүүлсэн, оролцогчдыг татсан арга хэмжээ болсон. | |
| 1.11 | **Арга хэмжээ-11:** Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэн задгай талбай байгуулна. | | | | | “Бороогоульд” ХХК 243,0 сая, “Mindtech” ХХК 9,0 сая төгрөгийг нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалт хийж Баянгол спорт цогцолборын үйл ажиллагаа, эдэлгээг сайжруулах чиглэлээр урсгал засварын тендерийг зарлан “Сайн мод бид бүтээнэ” ХХК спорт цогцолборт их завсарыг төсөвт өртөгт багтаан хийж гүйцэтгэсэн. Мөн Баянгол спорт цогцолборт орон нутгийн 85,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тамирчдын амрах байр, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөөний засварын ажлыг “Сайн мод бид бүтээнэ” ХХК хийж гүйцэтгэсэн.<br>Спортын газрын урсгал завсарын зардлаас санхүүжигдэх Баянгол спорт цогцолборын дээвэр, хүзүүвчийн барилгын засвар 50,0 сая төгрөгийн засварын ажлыг “Гонирын зам” ХХК, Сайхан спорт цогцолборын ариун цэврийн өрөөний засвар 20,0 сая,төгрөгийн засварын ажлыг “Өргөн цахиур” ХХК тус тус ажил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэх гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баруунбүрэн спорт цогцолборын заалны шал, хананы засвар 35,0 сая төгрөгийн засварын ажлыг "Ноён Азура"ХХК хийж гүйцэтгэсэн.<br>УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат нь сагсан бөмбөгийн стандартын иж бүрэн шитийг 28,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн.<br>Спорт цогцолборын үйл ажиллагаа, эдэлгээг сайжруулах чиглэлээр урсгал засварт **442,0** сая төгрөг, спортын хэрэглэл материал **101,0** сая нийт **543,0** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. | |
| 1.12 | **Арга хэмжээ-12:**<br>Спортын төрөлжсөн талбай, цэнгэлдэх хүрээлэн, гэр хороолол орон сууцны орчмын тоглоомын талбайн ашиглалтыг сайжруулна. | - | Спортын ба тоглоомын талбайн тоо | 2022 онд спортын төрөлжсөн талбай 8 тоглоомын талбай 24 | 2023 онд спортын төрөлжсөн 10 тоглоомын 25 талбай | Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг спортын 8 цогцолборт үйл ажиллагааг нь хэвийн хангах чиглэлээр 500000 төгрөгийн спортын бараа /сагсан бөмбөг, хөл бөмбөг, волейбол, волейболын тор, секундомер, шүгэл, онооны самбар/ нийлүүлэн 4000000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Орон сууц, гэр хорооллын дундах тоглоомын талбайг ашиглуулах чиглэлээр хураагдсан самбар, шидийг байрлуулах тоглоомын талбайг бүрэн ашиглуулах чиглэлээр багуудтай хамтарч ажилласан.<br>БТСУХорооноос 21 аймгийн БТСГазарт техник хэрэгсэл, спортын хэрэгсэл, тавилгад нийт 60,0 сая төгрөгийг шийдвэрлэн өгч үүний дагуу тавилга, техник хэрэгслийг 40,0 сая төгрөгөөр бүрэн шинэчилж жүдо бөхийн татамитай болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-2:** Спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан тамирчдын залгамж халааг бэлтгэх, өсвөрийн шигшээ багийн зохион байгуулалтыг сайжруулж тамирчдын амжилтыг бүс, улс, олон улс, тив дэлхийн хэмжээнд хүргэх. | | | | | | | |
| **Зорилт-2:** **Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн уралдааны шаталсан тогтолцоо зэрэглэлийг бий болгож, төр төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэн, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын бүс, улс, олон улс, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тамирчид, дасгалжуулагчдын сахилга хариуцлагыг сайжруулна.** | | 32,0 | Сургалт дасгалжуулалтын чанарт ахиц гарч төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа бэхжин тамирчдын ур чадвар, амжилт дээшилсэн байх | Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар салбар холбоод 21, бүс, улс, олон медаль-8, дасгалжуулагч-7 байна. | Спортын тэмцээн уралдаан явагдаж зохион байгуулалт сайжирч төрийн бус байгууллагуудын оролцоо нэмэгдэн тамирчдын амжилт ахисан байна. | -174 секц дугуйланд 4500 тамирчин<br>-Улсын аварга шалгаруулах 36 тэмцээнд 444 тамирчин<br>- Аймгийн чанартай Биеийн тамирын болон спортын 136 арга хэмжээнд иргэн 41508 иргэн<br>Хамтран ажилласан 42 байгууллага<br>- Спортын 21 холбоод дээр шинээр 3 холбоо /бүжиг, дардас, хавчаахай шагай/<br>- Жилд 14 сургалтанд 304 багш ажилчид, багш дасгалжуулагчид хамрагдсан. | 100 |
| 2,1 | **Арга хэмжээ-1:** Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн төрлийн тоог нэмэгдүүлэн сургалт дасгалжуулалтыг чанаржуулж тамирчдын ур чадварыг дээшлүүлэн бүс, улс, олон улсын чанартай тэмцээнд үзүүлэх амжилтыг ахиулна. | Орон нутгийн төсөв 30 000 0 | Өсвөрийн шигшээ багийн журмыг мөрдөн дасгалжуулагчдын онол, заах арга зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэн сургалтын төлөвлөлт, явц, үр дүнг сургалтын зарчмуудад тулгуурлан зохион байгуулж хэвшсэн байна. Спортын төрлийн тоо хичээллэгчдийн тоо | Өсвөрийн шигшээ баг спортын 5 төрөл 67 тамирчин | Өсвөрийн шигшээ баг спортын 8 төрөл болгож хичээллэгсдийг 115 хүргэнэ. | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн төрлийн тоог нэмэгдүүлэх сургалт дасгалжуулалтыг чанаржуулах чиглэлээр аймгийн Засаг дарга, ИТХуралд шигшээ багийн төрөлд 3 төрлийг нэмэгдүүлэхээр саналаа дэвшүүлэн тавьсан.<br>Өсвөрийн шигшээ баг спортын 5 төрөлд 72 тамирчин, 5 багш хичээллэж байна.<br>Үндэсний шигшээ багт аймаг орон нутгийн харьяатай 5 тамирчин хичээллэж тамирчдаас жудо бөхийн төрлөөр Хэрлэн, Энхрийлэн, хүндийн өргөлтийн төрлөөр Э.Билэгсайхан, боксын спортоор О.Есүгэн нар олимп болон дэлхийн авargad оролцох эрхийн төлөө өрсөлдөж Жудо бөхийн төрлөөр Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат улсын шигшээ багийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тамирчин Л.Энхрийлэн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хошой хүрэл медаль, боксын тамирчин О.Есүгэн Ази тивийн наадмаас хүрэл медаль хүртэж 2024 оны олимпод оролцох эрхээ баталгаажууллаа. | |
| 2,2 | **Арга хэмжээ-2:** Монгол үндэсний уламжлалт спортыг дэмжин хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлэн спортын 4 төрлийн сургалт дасгалжуулалт зохион байгуулна. | Орон нутгийн төсөв 2 000 0 | Үндэсний спортын дугуйлан ба хичээллэгчдийн тоо | 4 холбоо 6 дугуйлан<br><br>210 | Үндэсний бөх 4 Сурын 2 дугуйлан<br><br>250 хүн | Билгийн улирлын XYII жарны үзэсгэлэн болгогч Усан туулай жилийн сар шинийн баярт зориулсан Улс, аймгийн цолтой үндэсний бөхийн барилдаанд 64 бөх барилдаж Улсын арслан Э.Оюунболд, Улсын арслан Р.Пүрэвдагва, Улсын заан Н.Жаргалбаяр, Улсын начин Н.Баярбаатар нар шөвгөрч Улсын заан Н.Жаргалбаяр түрүүлж, Улсын арслан Р.Пүрэвдагва үзүүрлэн баяр наадмыг чимж, наадамчин олныг баярлууллаа.<br>Тус барилдааны үеэр Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж ахмад Бөхчүүд, Уяачид, Үндэсний сурын харваа Үндэсний шагайн харваачдад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа.<br>Сэлэнгэ аймгийн шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 04 дүгээр сарын 16-нд Сүхбаатар сумын Спортын бүрэн дунд сургуулийн зааланд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд МУҮДМ-6, МУДМ-1, МУГМ-2, МУХоМ-4, МУМ-7, АГМ-40, МУХарьшгүй М-1, хүндэт харваач -1 тус тус оролцлоо. Нийт 17 сум, 6 тосгоны 29 багийн 230 гаруй харваачид Багийн харваа болон Цуваа харвааны төрөлд цэц мэргэн, оюун ухаанаа уралдуулан өрсөлдлөө. Тулгар төрийн 2232 жил, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Их монгол улсын 817 жил, Ардын хувьсгалын 102 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 92 жилийн түүхт их ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу эрийн гурван наадам, шагайн харваан төрлүүдээр арга хэмжээг өргөжүүлэн зохион байгууллаа. Үндэсний бөхийн барилдаанд 128 бөхчүүд бяр чадал, уран мэхээ уралдуулан барилдаж Аймгийн заан Б.Ганбаяр түрүүлж Аймгийн арслан цол хүртэж сумын заан Б.Алтанбаяр үзүүрлэн Аймгийн заан цол хүртэн шинээр шөвгийн 4 үлдэн сумын начин Ш.Энхбаясгалан аймгийн начин цол хүртсэн бол үндэсний гурван сурын харваанд нийт 245 харваачид оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдөж аймгийн мэргэн цолтой харваачид 2 төрөн гарсан.<br>Сурын холбооны шинэчлэлийн дагуу өвлийн төрлийг хөгжүүлэх чиглэлээр мөсөн сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг хоёр дахь удаагаа зохион байгуулан тэмцээнд 17 сум, 6 тосгоны 50 гаруй тамирчид оролцож тэмцээнийг зохион байгуулалтын өндөр хэмжээнд сурын холбоотой хамтран зохион байгуулсан.<br>Үндэсний сурын өв уламжлал ёс заншил, ахмад харваачдад хүндэтгэл үзүүлсэн "Сурын дов" сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн Сурын холбоо, ЗДТГазар, Сэлэнгэ Бодонгууд клубтэй хамтран зохион байгууллаа. Сэлэнгэ бодонгууд клуб нь тус тэмцээнд оролцож байгаа ахмадууд болон урилгаар оролцож байгаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахмадуудад хүндэтгэл үзүүлэн 15 ахмадуудыг шагнаж урамшууллаа.<br>Нээлттэй тэмцээнд Дархан, Улаанбаатар, Сэлэнгэ аймгийн 7 сумын 150 гаруй харваачид оролцож цэц мэргэнээ сорилоо.<br>Үндэсний бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 насны ангиллаар Мандал суманд зохион байгуулан түүнд 230 гаруй бөхчүүд оролцон уран мэхээ уралдуулан барилдлаа.<br>Үндэсний бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 3 насны ангиллаар 20 аймаг 9 дүүргийн 87 бөхчүүд оролцож хурд хүч, уран мэхээ уралдуулан барилдлаа.<br>Тэмцээний үед Үндэсний бөхийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга оролцож У.Батмөнхийг улсын хөлийн цэцээр, гарын даагаар Г.Амархүү, Д.Энхбат, дэд гарын даагаар Ж.Төмөрсүх нарыг үндэсний бөхийн цолоор шагнагдсан.<br>2023 онд нийт үндэсний спортын 4 төрөлд 23 секц сургалтад 510 гаруй тамирчид хичээллэн 7 тэмцээнд 939 иргэнийг хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2,3 | **Арга хэмжээ-3:** Бүс, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцоно. | Улсын төсөв 20 000 0 | Бүсийн ба улс, олон улсын чанартай тэмцээнд оролцсон тэмцээний тоо, медалийн тоо | 2019 оны Бүсийн тэмцээнд 3 төрөлд 15 медаль, УАШТ-д 16 төрөлд 54 медаль ОУ-ын 4 тэмцээн- 12 медаль нийт 81 медаль | Бүс, улсын аваргын 2021 онд батлагдсан 37 төрлөөс 14 төрөлд оролцож 35 медаль, олон улс, тивийн тэмцээнд 2 төрөлд 3 медаль авсан байна. | Улсын болон олон улсын 36 тэмцээн, аймагт зохион байгуулсан 11 удаагийн бүс болон УАШТэмцээнд 4951 тамирчин, дэлхийн аварга, ази тив, гадаадын 3 тэмцээнд 54 тамирчинг хамруулж 43 алт, 34 мөнгө, 53 хүрэл медаль нийт 130 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн байна. Засгийн газрын 183 дугаар тогтоолын дагуу анх удаа хөдөө орон нутаг Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Хүүхдийн спортын YII наадам” –д анхан шатны тэмцээнүүдээс шалгарсан 230 гаруй тамирчид 30 гаруй албаны болон дасгалжуулагч багш нар аймгаа төлөөлөн 18 төрөлд оролцож 10 төрлөөс 13 алт, 10 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж 21 аймгаас тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2,4 | **Арга хэмжээ-4:** Тамирчдыг урамшуулах хөшүүргийг нэвтрүүлэх чиглэлээр Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар "Улс болон олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах, их наадмын тэмцээнээс медаль хүртсэн тамирчин дасгалжуулагчдад мөнгөн урамшуулах олгох" журмыг боловсруулан батлуулах . | Орон нутаг, хөгжил сан 5,000 0 | Улс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдын тоо | 0 | Улс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчдыг урамшуулсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 173-р тогтоолын 1.2 хавсралтын дагуу аймаг орон нутгийн харьяат болон орон нутгийн нэрийг дуурсгасан тамирчид дасгалжуулагчдыг урамшуулан сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх чиглэлээр аймгийн ИТХ-д журам боловсруулан батлуулахаар хүргүүлсэн. Спортын чиглэлээр амжилт гаргасан хүүхдүүдийг хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр тодорхойлон Аймгийн ЗДТГазраас шагнаж урамшуулсан.<br>Засгийн газрын 183 дугаар тогтоолын дагуу анх удаа хөдөө орон нутаг Баянхонгор аймагт зохион байгуулагдсан "Хүүхдийн спортын YII наадам" –д оролцож медаль хүртсэн 48 тамирчинд 4800000 төгрөгийн урамшуулал олгосон. | 100 |
| 2,5 | **Арга хэмжээ-5:** МБАТНаадам. ХСНаадамд орон нутагт хөгжиж байгаа спортын төрлүүдээр баг тамирчдыг бэлтгэн оролцуулах | | | | | МБАТНаадмын өвлийн төрөлд 3 төрлөөр оролцуулснаар цаны төрөлд 3 мөнгөн медаль хүртэж зуны 18 төрлөөр 230 тамирчинг оролцуулан 10 төрлөөс 13 алт, 10 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж 21 аймгаас тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн | 100 |
| 2,6 | **Арга хэмжээ 6** Шинэ тутам хөгжиж буй спортын төрлийн хамрах хүрээг тэлж хүн амд үзүүлэх биеийн тамир спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсөв 800 0 | Шинэ тутам хөгжиж буй гранд гольф ба дартсын спортын холбооны хамрах хүрээг спорт сонирхогчдын тоо | Софт волейболын спорт шинээр хөгжих суурь тавигдсан | Шинэ тутам хөгжиж байгаа гранд гольф ба дартсын спортын буй 2 төрлийн хамрах хүрээг нэмэгдүүлж сонирхогчдын тоог | Аймгийн ахмадын холбоотой хамтран шинэ тулгар хөгжиж байгаа гранд гольфийн спортыг орон нутагт хөгжүүлэх чиглэлээр иж бүрэн хэрэглэл материалтай болгож сургалт сурталчилгаа явуулан 200 гаруй иргэдийг хамруулсан.<br>Софт волейболын спортыг хөгжүүлэх чиглэлээр Сүхбаатар, Мандал, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 01%-д хүргэсэн байна. | Сайхан, Баруунбүрэн сумдад хичээллэж түүнд 80 гаруй тогтмол хичээллэгчтэй болсон<br>Дартсын спортын холбоог байгуулан энэ спортын төрлөөр сонирхолтой хүүхэд залуучуудын дунд спортыг сурталчлан тэмцээн уралдаануудад оролцуулан өргөжүүлж улмаар Улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Холбооны үйл ажиллагааг өргөжүүлэх хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэхээр анхны Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан тэмцээнд 6 сумын 70 гаруй тамирчин оролцлоо. Ахмадын софт волейболын тэмцээнийг Сайхан суманд зохион байгуулан түүнд 6 сумын 9 багийн 40 гаруй ахмадууд оролцсон.<br>Ахмадын холбоо нь шинэ хөгжиж байгаа грандгольфийн спортын сургалтыг төв цэнгэлдэх хүрээлэнгийн дэргэд явуулж Улсын аварга шалгаруулах тэмцээнд 6 тамирчинг оролцуулан 1 хүрэл медаль авсан амжилтыг үзүүлсэн.<br>2023 онд шинээр дартсын спортыг дэмжин холбоог байгуулан анхны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг хамтран зохион байгуулж 70 гаруй шидэгч тамирчид оролцсон. | |
| 2,7 | **Арга хэмжээ-7:** Багийн спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж хүн амд үзүүлэх үзүүлэх спортын ажил | | Спорт тоглоом багийн спортын хамрах хүрээг нэмэгдүүлж өймгийн сонирхогч хичээллэгсдийн хувийг өсгөх | Багийн спортын төрөлд сонирхогч хичээллэгчид 1280 хүрсэн | Багийн спортын 6 төрлийн хамрах хүрээг тэлж спорт сонирхогчдын тоог 1500 хүргэнэ | Спортын бүрэн дунд сургууль, гүнзгийрүүлсэн сургалттай ангиудыг нээн хичээллүүлснээр Сагсан бөмбөг, волейбол, хоккейн спортын төрлөөр мэргэжлийн сургалтыг явуулан сонгон шалгаруулалтыг хийж өсвөрийн улсын аваргад оролцуулснаар сагсан бөмбөгийн U- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанарыг сайжруулна. | | | | | 15, U-17 насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй 2,3 дугаар байр, волейболын тэмцээнд эрэгтэй тэргүүн байр, эмэгтэй 3 дугаар байр, хоккейн тэмцээнд баг тамирчид улсын аварга гэсэн эрхэм цолуудыг хүртсэн амжилтыг үзүүлсэн.<br>Өвлийн багийн спорт хоккейн талбайг засварлан хийж тамирчдын бэлтгэлийг хангуулан өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд тэргүүн байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. Мэргэжлийн багийн спортыг дэмжих чиглэлээр волейболын идэрчүүдийн УАШТэмцээн, сагсан бөмбөгийн U-18 насны Улсын аварга шалгаруулах тэмцээн, U-14 насны волейболын тэмцээн зэргийг аймгийн ЗДТГазар, бусад байгууллагуудын дэмжлэгтэйгээр орон нутагтаа хүлээн авч эхний байруудад шалгарсан амжилтуудыг үзүүлээд байна. | |
| **Зорилт -3:** Төрийн байгууллагын чиг үүргийг хангах | | | | | | | |
| **Зорилт-3:**<br>**Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэрийг хангаж мөрдөнө.** | | Улсын төсөв 1 000 0 Орон нутгийн төсөв 400 0 | Төрийн албанд мөрдөгдөх хууль, тогтоол шийдвэр хэрэгжсэн байх | Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, журмыг хэрэгжүүлэн ажиллах. | Төрийн байгууллагад мөрдөгдөх хууль, салбарын хууль тогтоомж, шийдвэр хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна. | Биеийн тамир, спортын тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй 20 гаруй бодлого шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 |
| 3,1 | **Арга хэмжээ-1:**<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын | - | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 90% | Хэрэгжилт-100% | Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн биелэлтийг гарган жилийн байдлаар БТСУХорооноос | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтэс болон Биеийн тамир, спортын улсын хорооны төрийн захиргааны удирдлагын хэлтэст хуулийн хугацаанд тайлагнана. | | | | | ирүүлсэн маягтын дагуу хугацаанд нь тайлагнан хүргүүлсэн | |
| 3,2 | **Арга хэмжээ-2:** Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн Баталгааг хангах аймгийн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | Улсын төсөв 1 4,000 0 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт -80 хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт-100 хувь | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр Нийгмийн халамж үйлчилгээний газар, ГБХЗХГазар, Цагдаагийн газар, Аймгийн ЗДТГазар, ЭМГазар, ОБГазар, БТСУХороо, ТАЗөвлөл, мэргэжил дээшлүүлэх сургалтуудад мэргэжилтнүүдийг урьж бүх ажилчдын дунд 14 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр ажлын туршлага, ур чадварыг харгалзан 25-40хувь хүртэл нийт ажилчдын 80 хувьд ур чадвар, үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгож ажилласан | 100 |
| 3,3 | **Арга хэмжээ-3:** Спортын мэдээллийн цахим санг бүрдүүлэх, баяжуулах, шуурхай, бодитой байх зарчмыг хангах мэдээлэл тогтмол оруулна. | Улсын төсөв 100 0 | Зохион байгуулсан арга хэмжээг спортын мэдээллийн цахим санд оруулсан хувь | 60 хувь оруулсан. | 90 хувийг цахим санд оруулсан байна. | Биеийн тамир спортын улсын хорооны хөрөнгө оруулалтаар байгууллага дээр шинэ дэвшилтэт технологи ухаалаг дэлгэцтэй хурал зөвлөгөөн сургалтад ашиглахаар ирүүлсэн тоног төхөөрөмжийг сургалтын танхимд байршуулан 2023 онд явагдсан 14 сургалтад 304 ажилтаныг бүрэн хамруулан, байгууллагын үйл ажиллагаанд 136 арга хэмжээг зохион байгуулсаныг мэдээллийн цахим санд байршуулан оруулсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | **Арга хэмжээ 4** Байгууллагын дотоод дүрэм ёс зүйн дүрмийг сахин төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэж үйлчилнэ. | | | | | Хууль тогтоомжийн дагуу байгууллагын дотоод журамд жил бүр шинэчилсэн найруулга хийгдэн түүнийг мөрдлөг болгон ажиллаж, байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгууллагын үйл ажиллагааны явцад ирүүлсэн 2 гомдол саналыг ёс зүйн зөвлөлөөр шийдвэрлүүлэн төрийн үйлчилгээ хэвийн явагдсан. | 100 |
| 3.5 | **Арга хэмжээ 5** Авлига хээл хахуулаас ангид байж хариуцлагыг өндөржүүлэн урьдчилан сэргийлэн ажиллана | | | | | Байгууллагын удирдлага болон спорт цогцолборуудын 8 удирдах ажилтануудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь гаргаж өгч ажиллаж байгаа. | 100 |
| **Дөрөв. Хяналт шинжилгээ үнэлгээ** | | | | | | | |
| 4.1 | **Арга хэмжээ-4:** Санхүүжүүлсэн төсвийн хүрээнд өр, авлага үүсгэхгүй батлагдсан төсөвтөө багтаан ажиллах, үр ашиггүй зардлыг багасган ажиллана. | Улсын төсөв | Байгууллагын төсвийн зарцуулалт ба үр ашиггүй зардлыг багасгасан хувь | Байгууллагын төсвийн зарцуулалт 92 хувь үр ашиггүй зардлыг багасгасан 8 хувь | Байгууллагын төсвийн зарцуулалт 90 хувь үр ашиггүй зардлыг багасгасан хувь 10 хувь | 2023 оны жилийн байдлаар Улсын төсвөөс 124157280 төгрөгийн санхүүжилт,<br>Орон нутгийн төсвөөс 113887400 төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааг хэвийн явуулж ирсэн. | 100 |
| 4.2 | **Арга хэмжээ-5:** Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллана. | Орлого 35,400 0 | Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь | 88.7% | Өөрийн үйл ажиллагааны орлогын 100 хувь биелсэн байна. | Өөрийн орлогын үйл ажиллагааг сумдын 8 цогцолборт хүн амын тоотой уялдуулан жилийн 67,000,000 төгрөгийн оруулан ажиллаж байна. | 100 |
| 4.3 | **Арга хэмжээ-6:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган хууль журмын дагуу холбогдох мэдээллийг бүрэн байршуулж ил тод байдлыг хангана. | - | Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан мэдээллийн хувь | Шилэн дансны мэдээллийн 90 хувь | /Санхүү төрийн сангийн хэлтэст/ 100 хувь оруулсан байна. | Шилэн дансны мэдээллийн дагуу хугацаанд нь өгч хугацаа хоцрогдолгүй мэдээлэл хүргэгдсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4 | **Арга хэмжээ-8:** Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаж аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтэс болон Биеийн тамир, спортын улсын хорооны төрийн захиргааны удирдлагын хэлтэст тогтмол тайлагнана. | - | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан тайланг хүргүүлсэн тоо | Санхүүгийн тайланг 2 удаа хүргүүлсэн | Ил тод байдлын тайланг аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтэс болон Биеийн тамир, спортын улсын хорооны төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн байна. | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж самбар ажиллуулан мэдээллийг сар бүр гарган, НДШимтгэл, татвар, ХАОАТатварын зэрэг бусад тайлан мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр хугацаанд гаргаж тогтмол тайлагнан ажиллаж байна. | 100 |
| 4.5 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулан дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний багтай болгож чадваржуулах | | Ажлын чиг үүргийг зохицуулан ажлын хуваарьт өөрчлөлт хийнэ. | Байгууллагын үйл ажиллагааг бодитой үнэлэх | Хагас бүтэн жилээр аудит хяналт шинжилгээ үнэлгээ хийгдэж явуулсан байна. | Байгууллага хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтантай болж байгууллагын үйл ажиллагаа, хагас бүтэн жилийн тайлан мэдээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийн явуулан ажиллаж байна. | 100 |
| Тав. Хүний нөөц нийгмийн баталгаа | | | | | | | |
| 5.1 | Биеийн тамирын арга зүйчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах | Улсын төсөв | Сургалтанд хамрагдсан арга зүйчдийн тоо | 9 арга зүйч | 10 арга зүйч | 2023 онд цахим хөгжлийн жил болгон зарласантай холбогдуулан мэргэжил, сургалт дасгалжуулалт, мэдлэг чадварын талаарх сургалтыг 14 удаа явуулан 100 хувь багш, ажилчид хамрагдсан.<br>• Биеийн тамир улсын хорооноос - 5<br>• Төрийн албаны салбар зөвлөлөөс-2<br>• Мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2<br>• МСБХолбооны шүүгчийн сургалт<br>• Байгууллагын доторх 5 сургалт<br>Арга зүйч багш дасгалжуулагч нарын мэргэжил, зэрэг шатлал дээшлүүлэх цуврал сургалтад хамрагдах багш нарын судалгааг гаргаж эхний ээлжинд 20 хүнийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туршлага судлах сургалтад Улаанбаатар хотын Баянгол, Чингэлтэй дүүргийн БТСХороотой хамтарсан 2 хоногийн сургалтанд хамруулж, арга зүйч нарын мэргэжил дээшлүүлэх 2 сургалтад 21 хүнийг хамруулсан. | |
| 5.2 | Спортын холбоодоос зохион байгуулж байгаа дасгалжуулагч шүүгчдийн сургалтанд байнга хамруулах | Орон нутаг төсөв 1,5 | Сургалтанд хамрагдсан багш дасгалжуулагчдын тоо | 6 багш | 2023 онд явагдсан сургалтуудад бүрэн хамруулсан байна. | Хүүхдийн спортын наадмын үйл ажиллагаатай холбоотой 2 сургалтад бүх багш нарыг хамруулж, Буриад улсын БТСХороотой тохиролцсоны дагуу чөлөөт бөхийн төрлөөр Улан - Үд хотод 21 хоногийн багш, тамирчдын хамтарсан сургалт хийгдсэн.<br>Сагсан бөмбөгийн U-18 насны Улсын аварга шалгаруулах тэмцээний үеэр Монголын сагсан бөмбөгийн холбоонд тавьсан хүсэлтийн дагуу олон улсын шүүгч Ганзориг ирж аймгийн багш дасгалжуулагч сагсан бөмбөг сонирхогчдын дунд дасгалжуулалт, шүүлтийн дүрмийн талаар 4 хоногийн сургалт явуулж 21 хүнд сертификат гардуулсан. Мэргэжлийн багш нарыг спортын чиглэлийн дагуу сумдад ажиллуулан хоорондын туршлагаа солилцож хамтарсан бэлтгэлээр хангуулан мэргэжлийн тамирчдыг бэлтгэх зорилтыг хангуулахаар ажиллаж байна. | 100 |
| 5.3 | Монгол үндэсний уламжлалт спортыг дэмжин хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлэн спортын 4 төрөлт сургалт дасгалжуулалт зохион байгуулах | Орон нутаг төсөв 2000,0 | Үндэсний спортын дугуйлан ба хичээллэгсдийн тоо | 4 холбоо 6 дугуйлан 210 | Үндэсний бөх 4 Сур 2 дугуйлан 250 хүн | 2023 онд нийт үндэсний спортын 4 төрөлд 23 секц сургалтад 510 гаруй тамирчид хичээллэн 7 тэмцээнд 939 хүнийг хамруулсан.<br>Үндэсний бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 3 насны ангиллаар 20 аймаг 9 дүүргийн 87 бөхчүүд оролцож хурд хүч, уран | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэхээ уралдуулан барилдлаа. Тэмцээний үед Үндэсний бөхийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга оролцож У.Батмөнхийг улсын хөлийн цэцээр, гарын даагаар Г.Амархүү, Д.Энхбат, дэд гарын даагаар Ж.Төмөрсүх нарыг үндэсний бөхийн цолоор шагнагдсан. | |
| 5.4 | Дасгалжуулагчийн төгсөлтийн дараах сургалтад өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчийг хамруулах | 0 | Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг эзэмшсэн байх | 2022 онд 1 багшийг онлайн сургалтанд хамруулж төгсгөсөн | Дасгалжуулагчийн төгсөлтийн дараах сургалтанд үе шаттайгаар дасгалжуулагчийг хамруулах | Сургалт дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээн наадамд оролцуулах, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу дасгалжуулагч багш нарыг зэрэг ахиулах сургалтад хамруулж, багш солилцоо буюу хамтарсан туршлага солилцох бэлтгэлээр 3 багш, давтан сургаж мэргэжил дээшлүүлэхээр 2 арга зүйчдийн давтан сургалтад 12 багшийг хамруулаад байна. | 80 |
| 5.5 | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгаа аймгийн хөтөлбөрийн дагуу эрх зүйн орчныг бүрдүүлэн ажиллах | Орон нутаг төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилтээр | Тухайн ондоо хэрэгжүүлж байсан | Нийт 57 ажилтаны нийгмийн асуудлыг шийдвэрлэх | Ажилчдын дунд ажиллах нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр 14 удаагийн сургалтыг зохион байгуулан, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр ажлын туршлага, ур чадварыг харгалзан 25-40 хувь хүртэл нийт ажилчдын 80 хувьд ур чадвар, үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгож ажилласан | 100 |

БИЕЛЭЛТИЙГ ГАРГАСАН:
АХЛАХ ДАСГАЛЖУУЛАГЧ С.ДАШДАВАА

ХЯНАСАН:
ДАРГА У.БАТМӨНХ

ТҮС0037 9057137

**БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

**Нэг: Хяналт шинжилгээний зорилго**

Биеийн тамир спортын газрын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг үр дүнг үнэлэн, дүгнэлт боловсруулан удирдлагыг үнэн бодит мэдээлэлээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжируулахад хяналт шинжилгээний зорилго оршино.

**Хоёр: Хяналт- шинжилгээ үндэслэл, үнэлгээний арга зүй**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 4,7-д заасаны дагуу 2023 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны " Журам шинчлэн батлах тухай" тогтоолын хавсралтаар батласан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг удирдлага болгов.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусагдсан 34 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг жилийн эцсийн зорилтод түвшин үр дүнтэй харьцуулан дүгнэсэн. Бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний хэрэгжилтийг аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилт хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо.

**Гурав: Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд 3 зорилгын хүрээнд 10 зорилт 34 арга хэмжээнд хяналт–шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулж 31 арга хэмжээ " үр дүнтэй" дүнтэй буюу 100 хувь 3 арга хэмжээ "тодорхой үр дүнд хүрсэн" 70-99 хүртэл хувь тус тус үнэлэгдэж зорилтын дундаж 98,7 хувьтай буюу " Тодорхой үр дүнд хүрсэн" байна.

| № | ЗОРИЛТЫН НЭР | Арга хэмжээний тоо | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|
| Биеийн тамир спортоор дамжуулан хүн амын амьдралын хэв маягт эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлж, хүн амыг эрүүл чийрэг болгох замаар хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэн төрөөс иргэдэд чанартай үйлчилгээг үзүүлснээр хүн амын амьдралын чанарт өөрчлөлт орж идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир спортын хөгжлийн түвшингээр тэргүүлэх зэрэгт хүргэх | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Идэвхтэй хөдөлгөөн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөл бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах | 12 | 97,8 |
| 2 | Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн уралдааны шаталсан тогтолцоо зэрэглэлийг бий болгож, төр төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэн, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын бүс, улс, олон улс, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тамирчид, дасгалжуулагчдын сахилга хариуцлагыг сайжруулна. | 7 | 98,5 |
| 3 | Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэрийг хханган мөрдөнө. | 15 | 100 |
| | Зорилтын дундаж | 34 | 98,7 |

Үр дүн,

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгож 3 зорилт 34 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнд хүрсэн ажил нь 98,7 хувьтай байна.

Дүгнэлт

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж үнэлгээг 98,7 хувьтай гэж дүгнэлээ.

Барилга байгууламжийн урсгал болон их засвар спортын талбай, хэрэглэл материалын үйл ажиллагаа нь төсөв санхүүтэй холбоотойгоор төлөвлөгдсөн үйл ажиллагаа хойшилж 2024 онд хийгдэхээр төсөвлөгдсөн.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ,
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г. ЭНХТҮВШИН